

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР /2009-2012 ОН/

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг бататгаж, “Аймгийн хөгжлийн хөтөлбөр/2008-2023/”-тэй нягт уялдуулан 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн зорилт нь:

- Эдийн засгийн бүтцийг шинэчлэх эхлэлийг тавьж, аймгийнхаа нийт өрхийн амьдралын чанарыг дээшлүүлэх
- Үйлдвэрлэл үйлчилгээний салбарт шинэ техник, технологи нэвтрүүлэх санал санаачилгыг бүх талаар дэмжиж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлэх
- Нийгмийн салбарын үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэдэд хүргэх мэдээллийг хүртээмжтэй болгох
- Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахдаа иргэд олон түмэн, байгууллага аж ахуйн нэгжийн идэвхи санаачилгыг өрнүүлж эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилгоор жил бүр тодорхой “УРИА” дэвшүүлж ажиллах

2009 он “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил”

2010 он “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил”

2011 он “Бүтээн байгуулалт-Хөрөнгө оруулалтын жил”

2012 он “Нийгмийн салбарын үйлчилгээний чанарын жил”

Нэг. Эдийн засгийн хүрээнд

- 1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 12-оос доошгүй хувьд хүргэж, үйлдвэр үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийг тогтворжуулна.
- 1.2. Мэдлэгт суурилсан эдийн засаг, инновацийн тогтолцоог бүрдүүлж эхлүүлнэ.
- 1.3. Эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлж хамтарсан үйлдвэр байгуулах санал санаачилгыг тэргүүн ээлжинд дэмжинэ.

- 1.4. Банк санхүүгийн үйлчилгээг өргөжүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.5. Зардлын оновчтой бүтэц бий болгон, төсвийг зохистой түвшинд төлөвлөж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлнэ.
- 1.6. Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан, төсвийн ил тод байдлыг хангана.
- 1.7. Нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 1.8. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл-мэдээлэл, хөрөнгийн үнэлгээг сайжруулна.
- 1.9. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагааг дээшлүүлж, хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлж, өмч хувьчлах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.10. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг Төв аймгийн аж ахуйн нэгжээр бүртгэх ажлыг зохион байгуулж, татварын орлогын бааз суурийг өргөтгөн, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр бий болгоно.
- 1.11. Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, үр дүнгээр нь урамшуулал, хариуцлага тооцдог тогтолцоог боловсронгуй болгоно.
- 1.12. Татварын ил тод байдлыг дээшлүүлж, татвар ногдуулалт хураалтад тавих хяналтыг эрс сайжруулна.
- 1.13. Албан ёсны статистикийн мэдээ тайланг хүлээн авах болон статистикийн ажил үйлчилгээг бүх сумдад хүргэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- 1.14. Албан ёсны болон захиргааны, салбарын статистикийн тогтолцоо, арга зүйг боловсронгуй болгон сайжруулна.
- 1.15. Хүн ам, орон сууцны улсын тооллогыг зохион байгуулж явуулна.

Хоёр. Хөдөө аж ахуйн хүрээнд

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг хэлбэрээр ажиллахыг зээлийн хөнгөлөлт үзүүлэх, гадны тусламж, төсөлд хамруулах зэргээр дэмжинэ.

2.2. МАА, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүүтэй зээл / лизинг /-ээр олгохыг дэмжинэ.

2.3. Малчдын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч бага оврын 300-аас доошгүй

тракторыг дагалдах тоног төхөөрөмжийн хамт малчдад хөнгөлөлттэй үнээр олгоно.

2.4. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах биржийн сүлжээ байгуулна.

2.5. Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах байгуулна.

2.6. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангана.

2.7. 2012 онд цэвэр, эрлийз болон цөм сүргийн малын тоог 300.0 мянгаас доошгүйд хүргэж, цөм сүрэг, нийт хээлтүүлэгч малд жил бүр хянан баталгаажуулалт явуулан үйлчилгээний зардлыг зохих журмын дагуу олгож, ажлын үр дүнг сайжруулна.

2.8. Эрчимжсэн фермерийн аж ахуйн бүс нутагт жилд дунджаар 300-аас доошгүй үнээнд зохиомол хээлтүүлэг хийж, үр дүнг 80.0-аас доошгүй хувьд хүргэнэ. Мөн 2012 он гэхэд 500- аас доошгүй малд хөврөл үрээр хээлтүүлэг хийнэ.

2.9. 2012 онд мах, сүү болон бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтад үржүүлдэг аж ахуй,

фермерийн тоог 380-д хүргэж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэн нэгжийн ашиг шимийн гарц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр малчдын ахуй амьдралыг сайжруулна.

2.10. Бэлчээрийн хүрэлцээ даацын байдалд судалгаа хийж, цаг уурын хүндрэл бэрхшээлийг хохирол багатай давах зорилгоор отрын бүс нутгийг шинэчлэн тогтоож зохистой ашиглахын зэрэгцээ отор нүүдлийн зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.11. Бэлчээр ашиглалтыг сайжруулах аймгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.12. Сум дундын отрын бүс нутгийг нарийвчлан тогтоож, хамгаалалтанд авах, нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулах талаар аймгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэн ажиллана.

2.13. Бэлчээр талхлагдал, элэгдлийн талаар нарийвчилсан судалгааг хийж, бэлчээрийг хуваарьтай, зохистой ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.14. Бэлчээр ашиглалтыг сайжруулахын тулд ердийн хөсөг ашиглах уламжлалыг сэргээнэ.

2.15. Бэлчээрийн мал маллагаанд нутгийн үүлдрийн малыг өөр дотор нь шилж сонгон цэвэр үржүүлгийн аргыг хэрэглэхээс гадна өндөр ашиг шимт үүлдэр омгийн малаар эрчимжсэн мал аж ахуйг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.16. Махны чиглэлийн фермерийн аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Лүн, Жаргалант, Алтанбулаг, Баянцагаан, Баяндэлгэр сумдад түлхүү хөгжүүлж, энэ чиглэлийн фермерийн аж ахуй 2012 онд 10-аас доошгүйд хүрнэ.

2.17. Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг Борнуур, Баянчандмань, Батсүмбэр, Сүмбэр, Жаргалант, Эрдэнэсант, Баянцогт, Баянхангай, Мөнгөнморьт, Аргалант сумдад түлхүү хөгжүүлж, загвар фермерийн аж ахуй 15-тай болно.

2.18. Гахай, тахиа, зөгий, туулайн аж ахуйн тоог жил бүр нэмэгдүүлж, 2012 онд 80-аас доошгүйд хүргэж, бүтээгдэхүүний хэрэглээг өсгөнө.

2.19. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, сүргийн бүтэц, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулна.

2.20. Тэжээл үйлдвэрлэлийн аймгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх замаар таримал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.21. Малын тэжээлд зориулж олон наст ургамал тариалалтыг нэмэгдүүлж, таримал тэжээлийг 2500 га, царгас 100 га-аас доошгүйд тариалалт хийнэ. Ингэснээр малын тэжээлийн хангамж сайжирна

2.22. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, Баянчандмань, Жаргалант, Баянцогт, Угтаалцайдам, Эрдэнэсант, Цээл, Зуунмод сумдад багсармал, холимог, хорголжин, эрдэс тэжээлийн үйлдвэр, цехийг өргөтгөж, шинээр нэмж байгуулан жилд дунджаар 10.0 мянган тн-оос доошгүй тэжээл үйлдвэрлэнэ. Тэжээлийн үйлдвэр, цехийн тоо 8-аас доошгүйд хүрнэ.

2.23. Мал аж ахуйн үйлдвэрлэл бизнесийг дэмжиж, малчдын орлогыг нэмэгдүүлэх, мэргэжил эзэмших боломжийг бүрдүүлж “Мэргэжилтэй малчин” бэлтгэх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.

2.24. Мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгон оношилгоо, шинжилгээний чадавхийг дээшлүүлж, Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

2.25. Малын эмч нарыг мэргэжлийн сургалт семинарт улирал бүр хамруулж халдварт

өвчний үед тандалт судалгаа хийх мэргэжил арга зүйн чадварыг дээшлүүлнэ.

2.26. Мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэн, малын угаалга, тарилга, туулгалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцуулан санхүүжүүлнэ.

2.27. Халдварт өвчний голомтуудыг байр зүйн зураглалд оруулан бүрэн хяналтанд авна.

2.28. Мал эмнэлгийн лабораторийн байрыг засаж, төслийн 100 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг авах нөхцөл бүрдүүлж, мал эмнэлгийн лабораторийг олон улсын стандартад нийцүүлнэ.

2.29. Мал эмнэлгийн анхан шатны мэдлэг, малын уламжлалт эмчилгээний аргад малчид иргэдийг сургах зорилгоор Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг түшиглэн бүх сумдад малын эрүүл мэндийн зөвлөх ажиллуулна.

2.30. Мал, эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний үнийн тарифыг шинэчилнэ.

2.31. “Атрын 3 дахь аян” тариалан хөгжүүлэх хөтөлбөр, дэд хөтөлбөр газар тариалангийн

бодлогыг тэргүүлэх зорилт болгон хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэд, газар тариалангийн чиглэлээр дадлага туршлагатай иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хамтран ажиллаж, шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.32. Үр тариа 50000 га, төмс 4000 га, хүнсний ногоо 1100 га-д тус тус тариалж, газар тариаланд улаан буудайн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэн, улсын хэмжээний үр тарианы 20-оос доошгүй хувийг үйлдвэрлэж, аймгийнхаа гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.

2.33. Баянчандмань, Эрдэнэ, Заамар сумдын МСҮТөвийг түшиглэн мэргэшсэн механикжуулагч, ажилчдыг бэлтгэхээс гадна агрономичдыг хүлэмжийн аж ахуйн чиглэлээр шууд харилцаат мужуудад болон дотооддоо дадлагажих сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

2.34. Эзэмшсэн талбайгаа бүрэн ашиглаж нэгж талбайгаас өндөр ургац хураан авсан иргэд, ААНэгжийг урамшуулах бодлого баримтална.

2.35. Тариаланд тохиромжтой газрын тооллогыг сум бүрээр хийж, тариаланд тохирохгүй газрыг бэлчээрт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.36. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, таримал ургамлыг өвчин хортон, хог ургамлаас хамгаалах, бордох байгальд ээлтэй экологижсон технологи нэвтрүүлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

2.37. Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Цээл, Жаргалант, Сүмбэр болон шаардлагатай сумдад услалтын системийг засварлах шинэчлэх ажлыг хийснээр усалгаатай тариаланг 3000 га-гаас доошгүй талбайд хүргэнэ.

2.38. Үр бордоо, хор гербицидийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх арга хэмжээ авна.

2.39. Төмс, хүнсний ногоог орон нутгийн бордоогоор, үр тариаг эрдэс бордоогоор бордож, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.40. Тариалангийн болон бэлчээрийн мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулж хийнэ.

2.41. Хөрс байгаль цаг уурын нөхцөлд зохицсон таримал ургамлын үрийн нөөцтэй болно.

2.42. Өрхийн тариаланд суурин өрхийн 65-аас доошгүй хувийг хамруулж, бороо цасны усыг хуримтлуулан усалгаанд ашиглана.

2.43. Сум бүрийг агропарктай болгосноор хүлэмжийн аж ахуйн талбайг 67125 квм-д хүргэж, 14000 тн-ын багтаамж бүхий төмс, хүнсний ногоо хадгалах зоорьтой болж жимс жимсгэний тариалалтыг 28% -иар нэмэгдүүлж 50 га-д хүргэн Агропаркийг түшиглэж мөөг тариалах технологийг судална.

2.44. Хүлэмж, зоорь, жимс, жимсгэний аж ахуйг эрхлэн хөгжүүлэхийг бодлого төлөвлөгөөтэйгээр дэмжинэ.

2.45. Өндөр хүчин чадалтай олон удаагийн үйлдлийг нэг явалтаар гүйцэтгэдэг орчин үеийн техникийг тоног төхөөрөмжийн хамт, урт хугацаатай, бага хүүтэй зээл, түрээс лизингээр олгох болон төлбөрт үйлчилгээгээр үйлчилдэг хэлбэрийг дэмжинэ.

2.46. Атрын 3 дахь аяны хүрээнд үр тарианы зориулалт бүхий трактор, комбайны парк шинэчлэлтийг 80%-д хүргэнэ.

2.47. Тариалан эрхлэгчдэд зориулж бага оврын 500-аас доошгүй тракторыг дагалдах тоног төхөөрөмжийн хамт хөнгөлөлттэй үнээр нийлүүлж, дунд том оврын техникийн лизингийн үйлчилгээ үзүүлнэ.

2.48. Техник дундын үйлчилгээний паркийн ашиглалтыг сайжруулна.

2.49. Хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж түүний ажлын эд ангиудыг үйлдвэрлэх болон угсрах жижиг цех байгуулах асуудлыг судалж, холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.

2.50. Цээл, Баянчандмань, Борнуур, Баянцогт сумуудын техник дундын үйлчилгээний паркийн иргэдэд үйлчлэх үйл ажиллагааг хүртээмжтэй болгосоноор үйлчлүүлэх иргэд, талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.51. Баянчандмань сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиглэж хөдөө аж ахуйн чиргүүл дүүжин машины хуучин эд ангийг сэргээн засварлах, бага оврын трактор, тоног төхөөрөмжийг угсрах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авна.

2.52. Хүнсний салбарт орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэн үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан экологийн цэвэр бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж экспортод гаргах боломжийг судална.

2.53. Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр жил бүр 50-иас доошгүй худагт засвар шинэчлэлт хийж, бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлнэ.

2.54. Инженерийн хийцтэй услалтын системүүдийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлж, хүнсний ногооны талбайн 60-аас доошгүй хувийг усалгаатай болгоно.

2.55. Усны хайгуул хийж усалгаатай газар тариалан эрхлэх бүс нутгийг тогтооно.

Гурав. Дэд бүтэц, үйлдвэр, үйлчилгээний хүрээнд

3.1. Бүсийн тулгуур төв Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мөрдөн, ногоон байгууламж, спорт тоглоомын талбай байгуулах болон байшин хоорондын зайг барилгын норм дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

3.2. Зарим сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулна.

3.3. Сум суурин газруудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу /зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбай/ тохижуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.4. Өндөр довд “Шинэ Зуунмод” хотхоныг байгуулах бэлтгэлийг хангаж эхлүүлнэ.

3.5. Зуунмод хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн засварлаж ашиглалтанд оруулна.

3.6. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж Төвийн бүсийн тулгуур төвд 200-гаас доошгүй орон сууц бусад сумдад 8-аас доошгүй айлын орон сууцыг шинээр барина.

3.7. Нийтийн зориулалттай орон сууцнуудыг инженерийн шугам сүлжээнд холбох, хэрэглээний халуун устай болгох, дээврийг засварлах зэргээр хүн амын ая тухтай амьдрах нөхцөл бололцоог хангана.

3.8. Гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц буюу цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбож амины орон сууцтай болох боломжийг бүрдүүлнэ.

3.9. Хот, сум суурин газруудад сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төвүүдийг шинээр барих ажлуудыг хийнэ.

- Биеийн тамир спорт, урлагийн цогцолбор, соёлын төвийн барилгыг шинээр барих болон өргөтгөх ажлыг Баян, Заамар, Баяндэлгэр, Зуунмод, Баян-Өнжүүл сумдад хийж гүйцэтгэнэ.

- Халдвартын төвийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.

-Боловсрол соёлын газрын барилгыг барьж ашиглалтанд оруулна.

-Сургуулийн дотуур байрны барилгыг, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянцогт, Бүрэн, Мөнгөнморьт, Баянжаргалан, Батсүмбэр, Баянчандмань суманд шинээр барьж, Угтаалцайдам суманд өргөтгөнө.

-Сургуулийн хичээлийн байрны барилгыг Баянчандмань, Зуунмод суманд шинээр барина.

-Хүн эмнэлгийн барилгыг, Баянцогт, Батсүмбэр, Баян, Бүрэн, Заамар суманд шинээр барьж, засварлан, Баян-Өнжүүл, Борнуур, Эрдэнэсант сумдад өргөтгөл хийнэ.

- Хүүхдийн цэцэрлэгийн барилгыг, Батсүмбэр, Бүрэн, Аргалант суманд шинээр барьж, Алтанбулаг суманд өргөтгөл хийнэ.

-Сумын ЗДТГ-ын барилгыг, Эрдэнэсант, Эрдэнэ, Борнуур, Мөнгөнморьт, Өндөрширээт суманд шинээр барина.

3.10. Нийгмийн салбарын барилга байгууламжийг засварлах дарааллыг шинэчлэн тогтоож, засварлана.

3.11. Эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг нь иж бүрэн шинэчлэх техникийн шинэчлэл хийнэ.

3.12. Зуунмод хотын дулааны станцыг техник технологийн хувьд шинэчлэх арга хэмжээ авна.

3.13. Сэргэлэн сумын нутаг Салхит ууланд салхин цахилгаан станц байгуулж эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.14. Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.

3.15. Эрдэсжилт, хатуулаг ихтэй, ундны усны шаардлага хангахгүй байгаа Баянхангай, Аргалант, Жаргалант, Цээл, Угтаалцайдам, Сүмбэр, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Батсүмбэр, Баянчандмань, Баянцагаан, Борнуур, Өндөрширээт, Эрдэнэ сумдад ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах арга хэмжээ авч, хүн амыг стандартын шаардлага хангасан усаар хангана.

3.16. Хөшигийн хөндийд Олон улсын нисэх онгоцны буудлыг барьж байгуулахад орон нутгийн оролцоог хангана.

3.17. Орон нутгийн авто зам, гүүр барих, засварлах, тэмдэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

3.18. Авто замыг шинэчлэх, засварлах ажлыг Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумдад гүйцэтгэнэ.

3.19. Зуунмод-Зүүндэлгэр, Зуунмод-Баянхошуу, Зуунмод-Манзуширийн чиглэлийн авто замуудыг хатуу хучилттай болгоно.

3.20. Авто тээврийн хэрэгслийг суурин буюу зөөврийн тоног төхөөрөмжөөр оношлоно.

3.21. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийг шат дараатай хийлгэж, зорчигчдын тав тухтай зорчих нөхцлийг хангана.

3.22. Сумдад шууданг 7 хоногт 2 удаа, багт 1 удаа хүргэн, Аргалант, Баянцагаан, Баянцогт, Бүрэн, Борнуур, Дэлгэрхаан суманд төсвөөс дэмжлэг үзүүлж, бүсчлэлийн нэгдсэн кодоод хамруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

3.23. Төв суурин газруудын нийтийн аж ахуйн хөгжлийн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

3.24. Айл өрх бүрийг интернэт хэрэглэгч болгох, малчид гар утас ашиглах боломж нөхцлийг бүрдүүлнэ.

3.25. Телевизийн олон сувгийг сум бүрт хүлээн авах боломжийг бүрдүүлнэ.

3.26. Эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн аялал жуулчлалыг дэмжинэ.

Үйлдвэржүүлэх бодлого

3.27. Сум бүрд 50.0 сая төгрөгийн “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” байгуулж

ажиллана.

3.28. Холимог үйлдвэрлэлийн “Үйлдвэр технологийн парк”-ийг Зуунмод хотод байгуулна.

3.29. Хүнд үйлдвэрийн паркийг Сэргэлэн сумын нутаг Цагаан хярд байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.30. Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт түшиглэсэн байгальд хор хөнөөлгүй шинэ техник, технологид тулгуурласан барилгын материалын үйлдвэр, цехүүдийг Баянчандмань, Архуст, Бүрэн, Эрдэнэсант, Сэргэлэн, Зуунмод сумдад бий болгоно.

3.31. Цементний үйлдвэрийг Сэргэлэн суманд байгуулна.

3.32. Баян сумын нутагт баригдаж байгаа “Утаагүй шахмал түлшний үйлдвэр”-ийг ашиглалтанд бүрэн оруулж, Батсүмбэр, Жаргалант, Заамар, Эрдэнэ сумдад шахмал түлшний жижиг үйлдвэр байгуулна.

3.33. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хэрэгцээг өөрийн аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах бодлого баримталж ажиллана.

3.34. Аймгийн төвд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.

3.35. Ноолуур, арьс шир, хонины ноос, малын хялгас, хөөврийг боловсруулах жижиг дунд үйлдвэрийг Баянжаргалан, Баянцагаан, Баяндэлгэр, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Алтанбулаг, Зуунмод зэрэг сумдад түлхүү хөгжүүлэх бодлого баримтлана.

3.36. Орон нутгийн онцлогт тохирсон экологийн цэвэр сүү, цагаан идээ, мах махан болон гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ногоо савлах жижиг цехүүдийг Эрдэнэсант, Мөнгөнморьт, Эрдэнэ, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Угтаал, Цээл, Зуунмод зэрэг сумдад түлхүү хөгжүүлнэ.

3.37. Худалдаа үйлчилгээний таатай орчинг бий болгоход дэмжлэг үзүүлэн хэрэглэгчээ дээдэлсэн үйлчилгээг бий болгоно.

3.38. Төвийн бүсийн хөгжлийн тулгуур төв Зуунмод хотод бөөний худалдааны төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

3.39. Түүхий эдийн төрөлжсөн захыг сумдад байгуулна.

3.40. Сумдад ахуйн үйлчилгээний “Жишиг” төв байгуулна.

3.41. Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хэрэглэгчийг чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангахад стандартчилал хэмжилзүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг сайжруулна.

3.42. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хянах аймгийн нэгдсэн лаборатори байгуулна.

3.43. Төсөвт байгууллагуудын цахилгаан эрчим хүчийг цагийн тарифт тоолуурт шилжүүлэх ажлыг ээлж дараатай хэрэгжүүлнэ.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн хүрээнд

4.1. Бага насны хүүхдийн хөгжлийг хангах сургалт, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.2. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

4.3. Боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлж, суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмшүүлж, оюунжсан бүтээлч, чадамжтай хvний нөөцийг нэмэгдvvлнэ.

4.4. Багш нарын тогтвортой ажиллах, тасралтгүй хөгжих орчин бүрдүүлж, ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангана.

4.5. “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлнэ.

4.6. “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.7. Насанд хүрэгчдийн болон сургууль завсардагчдын сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон хүртээмжтэй, чанартай АББ-ын тогтвортой үйлчилгээ бий болгоно.

4.8. Их дээд сургуулийн салбарыг аймагт байгуулах асуудлыг холбогдох мэргэжлийн байгуулаллагад тавьж шийдвэрлүүлнэ.

4.9. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-II”-ийн зорилтыг хангаж, 16-45 насны иргэдийн Монгол хэл бичгийн мэдлэгийн түвшинг ахиулна.

4.10. Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлж, англи хэлийг мэдээлэл харилцаа, ажил хэргийн гол хэрэгсэл болгоход байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.11. Орон нутагт ажиллах боловсон хүчний тогтвортой үйл ажиллагааг хангах аймгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4.12. Хүүхдийн төлөвшилд онцгой анхаарч сургалт, хүмүүжлийн ажлын нэгдлийг хангаж хүүхдийг хүмүүжүүлэн, хүүхэд хөгжих таатай нөхцлийг бүрдүүлнэ.

4.13. Аймгийн Хүүхдийн төлөө төвийг “Хүүхэд-Залуучуудын газар” болгон үйл ажиллагааг өргөжүүлж, хүүхэд залуучуудыг эрүүл чийрэг бие бялдартай, оюунлаг, хүнлэг, энэрэнгүй, сурч боловсрох эрмэлзэлтэй иргэн болж төлөвших нөхцлийг бүрдүүлнэ.

4.14. Залуу зохион бүтээгч төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

4.15. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн үйлчилгээний тоног төхөөрөмж, хэрэглэлтэй болно.

4.16. Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлж, нийтийн биеийн тамираар хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлж, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлнэ.

4.17. Аймгийн хэмжээнд улсын болон бүс нутгийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулна.

4.18. Их спортыг орон нутгийн бүсээр хөгжүүлж, өсвөрийн шигшээ баг хичээллүүлнэ.

4.19. Соёл урлагийн байгууллагуудыг мэргэжилтэй боловсон хүчнээр ханган чадваржуулж, хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.

4.20. Аймгийн соёл, урлагийн байгууллагууд, сумдын соёлын төвийг орчин үеийн хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материаллаг нөхцлийг бүрдүүлэн хүн амд мэдээлэл хүргэх төв болгоно.

4.21. Түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ маршруттай болно.

4.22. Аймгийн номын санг “Мэдээллийн нээлттэй төв” болно.

4.23. Музейг мэдээлэл, мэдлэгийн эх сурвалж болгож сан хөмрөгийг баяжуулна.

4.24. Монгол туургатан театрын уран бүтээлийн чанарыг мэргэжлийн шаардлагын түвшинд хүргэж, үзэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үзвэрийн төрөл, уран бүтээлийн цар хүрээг өргөтгөнө.

4.25. Аймгийн соёл урлагийг дэмжих сан байгуулна.

4.26. Иргэдийн оюуны эрэлт хэрэгцээнд нийцсэн соёл урлаг, нийтийн болон ахуйн соёл үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

4.27. Ардын уламжлалт ёс заншил болон урлаг соёлын өвөрмөц дэг арга барилыг өвлүүлж, сурталчлан, түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоно.

4.28. Ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрх бүрийн хэрэгцээтэй уялдуулан 6000 ажлын байр шинээр бий болгоно.

4.29. 35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

4.30. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, хөдөлмөр зуулчлалын үйлчилгээг чанаржуулна.

4.31. Нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

4.32. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уядуулж Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр бэлтгэсэн мэргэжилтэй ажилчдын 80-аас доошгүй хувийг Төв аймгийн иргэн байхаар тооцож, ажил олгогч аж ахуйн нэгжийн шаардлагад нийцсэн, ур чадвартай мэргэжилтэй ажилчид бэлтгэнэ.

4.33. Ажилгүйдлийн түвшинг 1.4 хувьд хүргэж бууруулна.

4.34. Малчдад хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо нөхөрлөл бүлэг болон зохион байгуулагдаж ажиллахыг дэмжинэ.

4.35. Шинээр гэр бүл бологсад, шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.

4.36. Шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300000 төгрөг нэг удаа, эхийн алдар 2-р зэргийн одонтой эхэд 500000 төгрөг, 1-р зэргийн одонтой эхэд 1000000 төгрөгийн тэтгэмж олгоно.

4.37. Эрх зүйн орчин бүрдсэн үед “Эх орны хишиг”-иргэн бүрт олгох 1.5 сая төгрөгийг зохион байгуулж олгоно.

4.38. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжих “Өрхийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж 1164-өөс доошгүй ядуу айл өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

4.39. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалж тэдэнд үйлчилдэг холбоод, ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.

4.40. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сувиллын газарт ахмадуудыг ээлж дараатайгаар амруулах арга хэмжээ авна.

4.41. Дайнд оролцсон ахмад дайчдын орон байрны нөхцлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

4.42. Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг өргөжүүлж, малчид, жижиг аж ахуй эрхлэгчид, ажилгүй иргэдийн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

4.43. Улсын их хурал, Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу цалин, тэтгэвэр, тэтгэмжийг тухайн үед нь нэмэгдүүлж олгоно.

4.44. Иргэний эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

4.45. Эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагчдын тусламж үйлчилгээний зардлыг хуулийн дагуу санхүүжүүлнэ.

4.46. “Тогтвортой амьжиргаа-II” төслийг хэрэгжүүлэн хөдөөгийн хүн амын эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны тогтвортой байдлыг бий болгоно.

4.47. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, хамралтыг сайжруулна.

4.48. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх стратеги, хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгож, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, хариуцлагыг өндөржүүлнэ.

4.49. Эмийн сангийн бүтэц үйл ажиллагааны стандартын хангалтыг сайжруулна.

4.50. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг эрүүл мэндийн салбарын чиг хандлагатай уялдуулан судлан тогтоож, үйл ажиллагааг аймаг сумын түвшинд төлөвлөн хэрэгжүүлнэ.

4.51. Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4.52. Эмнэлгийн гал тогоо, угаалгын газрын тоног төхөөрөмж, сантехник /цэвэр, бохир/-ийг шинэчлэн төвлөрсөн усан хангамжтай болгоно.

4.53. Байгалийн гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, хордлого, гэнэтийн аюул ослын үед авах арга хэмжээний нөөцийг бэхжүүлж, нэмэгдүүлнэ.

4.54. “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлж, эхийн эндэгдэл гаргахгүй, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

4.55. Хүн амын эрүүл мэндийг сайжруулж, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.

4.56. Нарийн мэргэжлийн эмч нарын явуулын тусламж үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.57. БЗДХ, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

4.58. “Цаасгүй эмнэлэг” төслийг аймгийн нэгдсэн эмнэлэгт үе шаттай хэрэгжүүлнэ.

4.59. Эрүүл мэндийн мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлнэ.

4.60. Эрүүл мэндийн газрын бүтцийг боловсронгуй болгож “Халдварт өвчинтэй тэмцэх аймгийн төв” байгуулна.

4.61. Яаралтай, хойшлуулшгүй, амь тэнссэн үеийн түргэн тусламжийг цаг алдалгүй хүрч үзүүлэх үндэсний түргэн тусламжийн сүлжээнд холбогдоно.

Тав. Байгаль орчин, газрын бодлогын хүрээнд

5.1. Экологийн тэнцвэрт байдлыг хангахуйц байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогц бодлогыг хэрэгжүүлэн хөгжлийн тогтвортой орчныг бий болгоно.

5.2. Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд орон нутгийн малчид, иргэдийг татан оролцуулах зорилгоор, тал хээрийн 14 суманд 40, бусад 13 суманд 60 иргэдийн нөхөрлөлийг байгуулан ой болон бэлчээрийн газрыг гэрээгээр эзэмшүүлэн хамгаалуулна.

5.3. Байгаль орчинтой харьцаж үйл ажиллагаа эрхэлж буй болон шинээр хүсэлт ирүүлсэн байгууллага аж ахуйн нэгжүүдийн төслийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулж, хяналт тавьж ажиллана.

5.4. Ойн түймэр, хортон шавьж, мэрэгчдээс хамгаалах, цогцолбор арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн, модны хэрэглээг багасгаж, хяналтыг хүчтэй болгон, “Ойн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

5.5. Аймгийн гадаргын болон гүний усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгаалалтыг сайжруулах, Туул, Хэрлэн голууд тэдгээрийн сав газрыг хамгаалж, ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах асуудлыг судалж шийдвэрлэн, булаг шандын эхийг тохижуулж, “Усны дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

5.6. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулах, тэдгээрийн байгалийн жамаар өсөж үржих, нөхөн сэргэх таатай нөхцлийг бүрдүүлж, ан амьтны болон ургамлын тархалт, нөөцийн судалгааг хийнэ.

5.7. Ашигт малтмалыг хаягдалгүй, дэвшилтэт технологиор олборлуулах, ашиглагдсан газрын нөхөн сэргээлтийг бодитой, чанартай, бүрэн хийлгэж, түүнд тавих хяналтыг нэмэгдүүлж, аймгийн уул уурхай эрдэс баялгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

5.8. Алтны бага нөөцтэй шороон орд болон усны хагалбар, голын ай сав газар, ойн сан, баян бүрд, байгалийн онцгой тогтоц бүхий газрууд, түүний хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, олборлохыг хориглон, хүний эрүүл мэндэд халтай арга технологиор уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг зогсоож, байгаль орчныг нөхөн сэргээх баталгаагүй бол эдийн засагт ямар ч ашигтай хөтөлбөр төслөөс татгалзана.

5.9. Хот суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүйгээр ангилан ялгах, дахин боловсруулах, дэвшилтэт техник, технологийг ашиглах замаар хог хаягдлын хэмжээг багасгаж, байгаль орчны бохирдлыг эрс бууруулна.

5.10. Экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.

5.11. Аймгийн хэмжээнд цөлжилтийн шалтгаан, үр дагаврыг судлан тогтоож, бэлчээрийн даацыг тохируулан ашиглах, үүлэнд нөлөөлж хур бороо оруулах арга хэмжээг үе шаттайгаар явуулж цөлжилтийг сааруулна.

5.12. Агаар мандлын чанар төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөнд тавих хяналт шинжилгээ мэдээллийн сүлжээг өргөтгөж, бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулан агаар бохирдуулагчтай хийх тэмцлийг эрчимжүүлнэ.

5.13. Түүхий нүүрсний хэрэглээг багасган, байгууллага аж ахуйн нэгжүүдийн уурын зуухыг төвлөрүүлж, тээврийн хэрэгслийг шинэчлэн хийн түлшинд шилжүүлэх замаар Зуунмод хот болон бусад төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулна.

5.14. Хөрсний элэгдэл, бохирдлыг багасгах, хөрстэй зүй зохистой харьцах талаар аймгийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

- 5.15. Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулна.
- 5.16. Аймгийн газрын кадастрын бүртгэлийн системийг автоматжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанартай, шуурхай болгоно.
- 5.17. Аймгийн газрын үнэлгээ төлбөрийг улам нарийвчлан газрыг арилжаанд орох чадвараар нь ялгавартай тогтоох судалгааны ажил зохион байгуулна.
- 5.18. Аймгийн уур амьсгал, усны нөөц, түүний хувьсан өөрчлөгдөх зүй тогтол, орчны бохирдолд байнгын хяналт шинжилгээ хийж, цаг агаарын төлөв байдлыг урьдчилан мэдээлж хэрэглэгчдэд шуурхай хүргэнэ.
- 5.19. Зуунмод голыг цэвэрлэн тохижилт хийж, иргэдийн амралт чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх бүс байгуулах асуудлыг судлан, хэрэгжүүлж эхэлнэ.

Зургаа. Нутгийн удирдлага, хууль хяналтын хүрээнд

- 6.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогоо бие даан тодорхойлох чадавхитай болоход дэмжлэг үзүүлж, нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан бодлого, хөтөлбөр, шийдвэрийг орон нутагт сурталчилж, хэрэгжилтийг зохион байгуулж, мэдээлэх, тайлагнах үйл ажиллагааны технологи, арга барилыг шинэчилнэ.
- 6.2. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийх гүйцэтгэлийн болон явцын хяналтыг сайжруулж түвшинг тогтооно.
- 6.3. Төрийн байгууллагад хяналт тавих, нөлөө үзүүлэх, дэмжлэг авах, ажил гүйцэтгэх зэрэг төрийн болон иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж төрийн албаны нээлттэй тогтолцоог төлөвшүүлнэ.
- 6.4. Төрийн албаны шинэтгэлийг гүнзгийрүүлэн, төрийн бүх шатны байгууллагын ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлж, төрийн үйлчилгээг ил тод, хүнд сурталгүй болгон хариуцлагыг бэхжүүлнэ.
- 6.5. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулна.
- 6.6. Сумдад иргэдэд үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-ний танхимыг бий болгон төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 6.7. Багийн хөгжлийг дэмжин сум бүрд жишиг багийн төв байгуулж, баг бүрийг 1 саяас доошгүй төгрөгийн сантай болгоно.
- 6.8. Хяналт шинжилгээ үнэлгээ хийх арга барилыг боловсронгуй болгоно.
- 6.9. Мэдээллийн технологийг ашиглан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, үр ашиг үр нөлөөг дээшлүүлнэ.

6.10. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаанд иж бүрэн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

6.11. Төрийн бүх шатны байгууллагын дотоод ажлыг сайжруулж, иргэдийн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай барагдуулж, төрийн албан хэрэг хөтлөлтөнд мэдээллийн цахим технологи нэвтрүүлнэ

6.12. Бүх шатны байгууллага иргэдийн хамтын хүчийг нэгтгэн, аймаг сумаа хөгжүүлэх бүтээлч ажлын төлөвлөгөөтэй ажиллаж, аймаг байгуулагдсаны 90-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлыг хангана.

6.13. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг дэмжиж, иргэдэд хүргэх мэдээллийн хүрээг өргөжүүлнэ.

6.14. Интернетэд суурилсан цаасгүй технологид шилжинэ.

6.15. Онцгой байдлын газрын гал унтраах анги, аврах отрядын бэлтгэл бэлэн байдал, шуурхай ажиллагааг дээшлүүлнэ.

6.16. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

6.17. Цэргийн штабын бие даасан шуурхай ажиллагааг эрчимжүүлнэ.

6.18. Аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэг салбаруудад хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

6.19. Аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн салбарт ажиллагсдыг ажил олгогч байгууллага нийгмийн даатгалд хамруулж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулж, зөрчлийг илрүүлэн, барагдуулах арга хэмжээ авна.

6.20. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг олон нийтийн хэвлэл мэдээллээр мэдээлнэ.

6.21. Хүний эрх, эрх чөлөөг хангах ажлын чанар үр нөлөөг дээшлүүлж, иргэдийн болон иргэдийн төлөөллийн байгууллагын хяналт мэдээллийн тогтолцоог сайжруулна.

6.22. Цагдан хорих байрны нөхцлийг олон улсын жишигт нийцүүлэн, шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.23. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулан иргэдэд үзүүлэх эрх зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

6.24. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргаж байгаа шийдвэрийн хууль зүйн үндсийг хангуулна.

6.25. Иргэдэд үзүүлэх иргэний бүртгэлийн үйлчилгээг “Нэг цэг”-т төвлөрүүлж, цахим хэлбэрт шилжүүлнэ.

6.26. Архивын баримтыг тоон мэдээллийн системд шилжүүлж, төрийн архивыг зориулалтын байртай болгоно.

6.27. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.

6.28. “Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого”-ыг хэрэгжүүлж, ажлын арга барил үр нөлөөг дээшлүүлнэ.

6.29. Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, согтууруулах ундаа үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, худалдан борлуулахад хяналт тавина.

6.30. Авилгаас урьдчилан сэргийлэх, авилгатай тэмцэх бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

6.31. Цагдаагийн алба хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, үйл ажиллагааг нь иргэдэд ойртуулах зорилгоор цагдаагийн бүх хэсэг тасагт Кабонь барьж байгуулах ажлыг зохион байгуулж дуусгана.

6.32. Нийгмийн хэв журам хамгаалах ажлыг эрчимжүүлж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн ажиллана.

6.33. Замын цагдаагийн бие бүрэлдэхүүний ажиллах нөхцлийг сайжруулж, техник тусгай хэрэгслээр үе шаттай ханган орон нутгийн болон улсын чанартай замын хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулна.

6.34. Цагдаагийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор томоохон суурин газруудад хяналтын камер суурилуулан, кримналистикийн шинжилгээнд дэвшилтэт техник, тоног төхөөрөмж нэвтрүүлж, автомашины парк шинэчлэлт хийнэ.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
/2009-2012 ОН/

2008.12.10.

Зуунмод

Д/д	Бодлогын хүрээ	Зорилтын тоо
1	Эдийн засгийн бодлогын хүрээнд	15
2	Хөдөө аж ахуйн хүрээнд	55
3	Дэд бүтэц үйлдвэрлэл үйлчилгээний хүрээнд	43
4	Нийгмийн хөгжлийн хүрээнд	61
5	Байгаль орчин, газрын бодлогын хүрээнд	19
6	Нутгийн удирдлага, хууль хяналтын хүрээнд	34
ДҮН		227

ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,
 АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

П.ЦЭРЭН

НЭГТГЭСЭН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.ЦЭВЭЛНЯМ